



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 125

Номгон

Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Хүрээмарал сумын харьяат Монгол улсын мэргэн Лхагвын Ядамсүрэнгийн /суурьтайгаа 4м өндөр/ хөөмөл зэсэн хөшөөг үр хүүхэд, харваачдын хандиваар хийсэн 80,0 /Наян сая/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн эзэмшигчээр аймгийн Биеийн тамир, спортын газрыг тогтоож, тухайн байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг 2020 оны 01 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтийг гаргаж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190715